


МӨНГӨНИЙ ТОЙМ

/2013 оны 4 дүгээр сар/

Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт



МӨНГӨ, САНХҮҮГИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2012		2013			
	11-р сар	12-р сар	01-р сар	02-р сар	03-р сар	04-р сар
Инфляци						
Улаанбаатар хотын инфляци						
сарын	-0.2	0.7	1.5	1.1	0.8	0.7
оны эхнээс	13.4	14.2	1.5	2.7	3.6	4.3
жилийн	14.2	14.2	12.7	11.1	9.4	9.8
Суурь инфляци						
сарын	-0.3	0.3	0.2	0.0	0.6	0.2
оны эхнээс	10.8	11.1	0.2	0.2	0.8	1.0
жилийн	10.7	11.1	9.6	8.7	9.2	9.3
Улсын инфляци						
сарын	0.2	0.8	1.8	1.0	0.8	1.1
оны эхнээс	13.1	14.0	1.8	2.8	3.6	4.8
жилийн	14.4	14.0	13.0	11.3	9.8	10.4
M2 мөнгө, тэрбум төгрөгөөр						
сарын өөрчлөлт, %	7,033.2	7,617.3	7,340.7	7,238.0	7,293.7	7,177.3
жилийн өөрчлөлт, %	-1.4	8.3	-3.6	-1.4	0.8	-1.6
Барг мөнгө, тэрбум төгрөгөөр	15.0	18.8	19.4	16.0	19.5	12.8
сарын өөрчлөлт, %	5,476.1	5,781.9	5,761.3	5,757.7	5,705.2	5,509.6
жилийн өөрчлөлт, %	-1.4	5.6	-0.4	-0.1	-0.9	-3.4
Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө, тэрбум төгрөгөөр	20.1	23.8	25.7	21.5	23.6	15.6
сарын өөрчлөлт, %	722.1	828.5	742.1	675.6	687.7	759.8
жилийн өөрчлөлт, %	0.6	14.7	-10.4	-9.0	1.8	10.5
Нөөц мөнгө, тэрбум төгрөгөөр	6.4	16.1	13.0	0.3	6.1	7.2
сарын өөрчлөлт, %	2,224.7	2,166.2	2,165.6	2,270.6	2,467.6	2,497.3
жилийн өөрчлөлт, %	3.6	-2.6	0.0	4.8	8.7	1.2
Зээлийн үлдэгдэл, тэрбум төгрөгөөр	46.7	30.5	39.4	49.7	36.0	46.6
сарын өөрчлөлт, %	6,867.8	6,990.5	7,139.8	7,168.5	7,383.6	7,764.0
жилийн өөрчлөлт, %	0.2	1.8	2.1	0.4	3.0	5.2
Чанаргүй зээл/Нийт зээл, %	26.3	23.9	26.4	25.6	27.7	30.8
Чанаргүй зээл/Нийт зээл, %	4.3	4.2	4.3	4.3	4.2	4.0
Хуу						
Хадгаламжийн ЖДХ	12.0	11.7	11.7	11.5	12.3	12.1
Зээлийн ЖДХ*	18.6	14.9	18.9	19.1	19.6	19.1
Ипотекийн зээлийн ЖДХ	14.40	15.27	17.00	16.80	15.70	n/a
ТБҮЦ-ны ЖДХ	16.3	15.5	14.2	13.5	13.3	12.9
Бодлогын хүү	13.25	13.25	12.50	12.50	12.50	11.50
БХЗ-ын ЖДХ	14.7	14.0	13.9	12.5	12.29	11.28

* Төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү

ТОВЧ ДҮГНЭЛТ

- Хэрэглээний үнийн улсын индекс¹ 2013 оны 4 дүгээр сарын эцэст өмнөх сараас 1.1 хувь, оны эхнээс 4.8 хувь, өмнөх оны мөн үеэс 10.4 хувь, Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индекс өмнөх сараас 0.7 хувь, оны эхнээс 4.3 хувь, өмнөх оны мөн үеэс 9.8 хувиар тус тус өслөө. Суурь инфляци¹ сарын 0.2 хувь, оны эхнээс 1.0 хувь, жилийн 9.3 хувь байв.
- Тайлант сард хүнсний барааны үнийн өсөлт сарын инфляцийн дийлэнх хувийг бүрдүүлжээ.
- Мөнгөний нийлүүлэлт өмнөх сараас 1.6 хувиар буурч, өмнөх оны мөн үеэс 12.8 хувиар өсч 7177.3 тэрбум төгрөгт хүрчээ. 2012 оны турш төгрөгийн хадгаламжийн жилийн өсөлтийн хурд саарч байсан бол гадаад валютын хадгаламжийн жилийн өсөлт нэмэгдэж байв. Харин 2013 оны хувьд валютын хадгаламжийн үлдэгдэл буурч жилийн өсөлтийн хурд нь саарсаар байна.
- Гадаад валютын хадгаламжийн үлдэгдэл 2012 оны 9 дүгээр сараас хойш буурсаар тайлант сард валютын хадгаламж өмнөх сараас 13.3 хувь буюу 158.1 тэрбум төгрөгөөр буурсан байна.
- Гадаад цэвэр актив өмнөх сараас 12.4 хувиар буурч 3456.7 тэрбум төгрөг болсон байна.
- Хадгаламжийн байгууллагуудын¹ зээлийн үлдэгдлийн жилийн өсөлт 2012 оны турш буурч байсан бол 2013 он гарсаар нэмэгдэж эхэллээ.
- Мөнгөний бодлогын зөвлөлөөс зээл, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, эдийн засгийн бодит сектор, бизнесийн идэвхжиллийг дэмжих зорилгоор 2013 оны 4 дүгээр сард мөнгөний бодлогын хүүг 1.0 нэгж хувиар бууруулж, 11.5 хувь болгох шийдвэр гаргасан.
- Мөнгөний бодлогын зөвлөлөөс 2013 оны 3 дугаар сард хүүний коридорыг шинээр нэвтрүүлэхээр шийдвэрлэсний дагуу 2013 оны 4 дүгээр сард 4 долоо хоногтой 50.0 тэрбум төгрөгийн үнэт цаас арилжаалсан байна.

Инфляци

Тайлант сард хүнсний барааны үнийн өсөлт сарын инфляцийн дийлэнх хувийг бүрдүүлжээ. Сарын инфляцийг 100 хувь гэж авч үзвэл 84.6 хувийг мах, махан бүтээгдэхүүн, 15.6 хувийг хүнсний бусад барааны үнийн өсөлт бүрдүүлсэн байна.



Тухайн сард нийт хэрэглээний сагсыг бүрдүүлж буй 329 бараа үйлчилгээнээс 64 бараа үйлчилгээний үнэ нь өсч, 23 бараа үйлчилгээнийх буурсан байна.

2013 оны 4 дүгээр сарын байдлаар жилийн инфляцийн 37.3 хувийг хүнсний барааны инфляци, 62.7 хувийг хүнснээс бусад бараа үйлчилгээний инфляци бүрдүүлсэн байна.


Үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт инфляцид хүнсний бараа, бүтээгдэхүүний инфляцийн үзүүлэх нөлөө 15.1 нэгж хувиар буурчээ.

Хэрэглээний үнийн индексийн жилийн өөрчлөлтийг бүлгээр нь авч үзвэл хүнсний барааны үнэ 11 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийнх 48.5 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшнийх 10 хувь, боловсролынх 16.1 хувь, зочид буудал, нийтийн хоолных

10.8 хувиар тус тус өссөн нь хамгийн өндөр өсөлттэй бүлгүүд байв.

Мөнгөний нийлүүлэлт


Тайлант сард гадаад валютын хадгаламжийн жилийн өсөлтийн хурд өмнөх сарынхаас 52.1 нэгж хувь, төгрөгийн харилцахынх 2.8 нэгж хувь, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгөнийх 1.1 нэгж хувь, төгрөгийн хадгаламжийнх 1.0 нэгж хувиар тус тус буурч, харин гадаад валютын харилцахынх 9.1 нэгж хувиар өссөн байна. Гадаад валютын хадгаламж буурсан нь импортын төлбөр төлсөнтэй холбоотой байна.



Мөнгөний үзүүлэлтүүдийн сарын өөрчлөлтийг авч үзвэл хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 48.9 тэрбум төгрөг, төгрөгийн харилцах 30.2 тэрбум төгрөгөөр тус тус өсч, харин төгрөгийн хадгаламж 29.1 тэрбум төгрөг, гадаад валютын хадгаламж 158.1 тэрбум төгрөг, валютын харилцах 8.3 тэрбум төгрөгөөр тус тус буурчээ.


Нийт мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн 83.7 хувийг төгрөгийн хадгаламж, 4.9 хувийг төгрөгийн харилцах, 3.8 хувийг гадаад валютын харилцах, 3.7 хувийг гадаад

валютын хадгаламж, 3.9 хувийг банкнаас гадуурх мөнгө тус тус бүрдүүлсэн байна. 2012 оны 8-11 дүгээр саруудад нийт мөнгөний жилийн өсөлтийн дийлэнх хувийг гадаад валютын хадгаламж бүрдүүлж байсан бол 12 дугаар сараас хойш төгрөгийн хадгаламжийн нөлөө нэмэгдсээр байна.



Хадгаламж

Нийт хадгаламж өмнөх сараас 3.8 хувь буюу 187.2 тэрбум төгрөгөөр буурч, харин өнгөрсөн оны мөн үеэс 17.9 хувь буюу 711.9 тэрбум төгрөгөөр өсч 4692.9 тэрбум төгрөг болов.



Гадаад валютын хадгаламжийн үлдэгдэл 2012 оны 9 дүгээр сараас хойш буурсаар тайлант

сард валютын хадгаламжийн жилийн өсөлтийн хурд өмнөх сарынхаас 52.1 нэгж хувиар буурсан байна.



Аж ахуйн нэгж, байгууллагуудын төгрөгийн хадгаламж өмнөх сараас 2.4 хувь буюу 9.6 тэрбум төгрөгөөр буурч, өнгөрсөн оны мөн үеэс 60.5 хувь буюу 146.9 тэрбум төгрөгөөр өсч 389.5 тэрбум төгрөг болсон бол иргэдийн төгрөгийн хадгаламж өмнөх сараас 0.6 хувь буюу 19.5 тэрбум төгрөгөөр буурч, өнгөрсөн оны мөн үеэс 19.5 хувь буюу 535.1 тэрбум төгрөгөөр өсч 3273.9 тэрбум төгрөгт хүрчээ. Гадаад валютын хадгаламж өмнөх сарынхаас 13.3 хувь буюу 158.1 тэрбум төгрөгөөр буурч, өнгөрсөн оны мөн үеэс 3.0 хувь буюу 29.9 тэрбум төгрөгөөр өсч 1029.5 тэрбум төгрөг болжээ.

Нийт хадгаламжийн 78.1 хувь нь төгрөгийн, 21.9 хувь нь валютын хадгаламж бөгөөд төгрөгийн хадгаламжийн нийт хадгаламжинд эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 3.2 нэгж хувиар буурчээ.

Гадаад, дотоод цэвэр актив

Гадаад цэвэр актив өмнөх сараас 12.4 хувиар буурч, өмнөх оны мөн үеэс 0.4 хувиар өсч 3456.7 тэрбум төгрөг, дотоод цэвэр актив өмнөх сарынхаас 11.2 хувь, өмнөх оны мөн үеэс 27.6 хувиар өсч 3724.3 тэрбум төгрөг болов. Гадаад цэвэр активын дийлэнх хувийг эзэлдэг гадаад валютын цэвэр албан нөөц 2013 оны 4 дүгээр сард өмнөх сараас 8.1 хувь буюу 270.3 сая ам.доллараар буурч, өмнөх оны мөн үеэс 16.5 хувь буюу 436.8 сая ам.доллараар өсч 3077.3 сая ам.доллар болов.



Нийт мөнгөний 48.1 хувь нь гадаад цэвэр активт, 51.9 хувь нь дотоод цэвэр активт байршиж байна.

Нөөц мөнгө

Нөөц мөнгө өмнөх сараас 1.2 хувь, өмнөх оны мөн үеэс 46.6 хувиар нэмэгдэж 2497.3 тэрбум төгрөгт хүрэв. Тайлант сард банкнаас гадуурх мөнгө 10.1 хувь буюу 48.9 тэрбум төгрөг, банкуудын касс 11.5 хувь буюу 23.2 тэрбум төгрөгөөр өссөн бол Төв банк дахь харилцах, хадгаламж 2.4 хувь буюу 42.4 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Банкуудын Төв банк дахь харилцах, хадгаламжийн нөөц мөнгөнд эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 11.2 нэгж хувиар нэмэгдэж 69.7 хувь болсон бол банкуудын кассын эзлэх хувь 3.2 нэгж хувиар буурч 9.1 хувь, банкнаас гадуурх мөнгөнийх 8.0 нэгж хувиар буурч 21.3 хувь болсон байна.

Зээл


Хадгаламжийн байгууллагуудаас¹ олгосон зээл өмнөх сарынхаас 5.2 хувь буюу 380.4 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 30.8 хувь буюу 1828.0 тэрбум төгрөгөөр өсч 7764.0 тэрбум төгрөгт хүрчээ. Хадгаламжийн байгууллагуудаас хувийн хэвшилд олгосон зээл өмнөх сараас 6.4 хувь буюу 253.7 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 29.6 хувь буюу 964.4 тэрбум төгрөгөөр өсч 4226.6 тэрбум төгрөгт, иргэдэд олгосон зээл өмнөх сараас 3.8 хувь буюу 127.9 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 34.2 хувь буюу 890.8 тэрбум төгрөгөөр өсч 3496.8 тэрбум төгрөгт хүрсэн байна.



¹ Хадгаламжийн байгууллагад арилжааны банкуудаас гадна мөнгөний нийлүүлэлтийн тооцоонд ордог харилцах, хадгаламж хэлбэрээр бусдаас хөрөнгө татан төвлөрүүлдэг санхүүгийн байгууллага (Хадгаламж, зээлийн хоршоо) хамрагдана.

Нийт зээлийг өмчлөгчөөр нь авч үзвэл 54.4 хувь нь хувийн хэвшил, 45.0 хувь нь иргэд, 0.4 хувь нь улсын байгууллага, 0.1 хувь нь бусад байгууллагад олгосон зээл байна.

Нийт зээлийн үлдэгдлийн 94.6 хувийг хэвийн зээл, 1.4 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 4.0 хувийг чанаргүй зээл тус тус эзлэв. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь өнгөрсөн оны мөн үеийнхээс 1.3 нэгж хувиар буурчээ.




Картын зээл

Иргэд, байгууллагуудын банкны картын зээлийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 2.5 хувийг бүрдүүлж байна.

Картын зээл 4 дүгээр сарын байдлаар 185.8 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 37.6 хувь буюу 50.8 тэрбум төгрөгөөр өсчээ. Картын зээлийн дийлэнхийг иргэдэд олгосон бөгөөд иргэдийн картын зээл өмнөх сараас 5.8 хувь буюу 10.1 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 185.7 тэрбум төгрөгт хүрсэн байна.


Картын зээлийг өмчлөгчөөр нь авч үзвэл 99.9 хувь нь иргэдэд, 0.1 хувь нь аж ахуйн нэгж байгууллагуудад олгожээ.



Картын зээлийн 96.1 хувь нь хэвийн, 1.6 хувь нь хугацаа хэтэрсэн, 2.3 хувь нь чанаргүй гэж ангилагджээ. Картын зээлийн 95.1 хувь нь төгрөгөөр, 4.9 хувь нь валютаар олгогдсон байна.

Хүү

Төв банкны үнэт цаасны жигнэсэн дундаж хүү 2013 оны 4 дүгээр сард өнгөрсөн оны мөн үеэс 2.0 нэгж хувиар буурч жилийн 12.9 хувь болов. Банкуудын төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү өнгөрсөн оны мөн үеэс 0.7 нэгж хувиар өсч жилийн 19.1 хувь болсон бол гадаад валютынх өнгөрсөн оны мөн үеэс 0.8 нэгж хувиар өсч жилийн 13.2 хувь болжээ.




Харилцахын жигнэсэн дундаж хүү өөрчлөлт багатай байгаа бөгөөд төгрөгийн харилцахын

жигнэсэн дундаж хүү жилийн 3.0 хувь, валютынх жилийн 1.4 хувьтай байна. Төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү өнгөрсөн оны мөн үеэс 1.1 нэгж хувиар өсч жилийн 12.1 хувь болсон бол валютын жигнэсэн дундаж хүү өнгөрсөн оны мөн үеэс 0.3 нэгж хувиар өсч жилийн 6.0 хувь болов.

Мөнгөний зах

2013 оны 4 дүгээр сард банк хоорондын захын арилжаагаар нийт 315.7 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгджээ. Эдгээр арилжааны жигнэсэн дундаж хүү жилийн 11.28 хувь байна.



2013 оны 4 сарын 2-ны өдрөөс 30-ны өдрийн хугацаанд банкууд дунджаар төгрөгийн заавал байлгах нөөцөд 706.1 тэрбум төгрөг, валютын заавал байлгах нөөцөд 343.6 тэрбум төгрөг байлгах шаардлагыг хангаж ажиллав. Банкууд төгрөгийн заавал байлгах нөөцөд 710.9 тэрбум төгрөг, валютын нөөцөд 1048.1 тэрбум төгрөг тус тус төвлөрүүлсэн байна.

Валютын ханш

Төгрөгийн ам. доллартай харьцах ханш 2013 оны 4 дүгээр сарын эцэст 1436.12 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 120 төгрөгөөр суларсан байна. Тайлант сард төгрөгийн ам. доллартай харьцах дундаж ханш 1417.41 төгрөг байв.

